МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

МУИС-ИЙН ЗАХИРГАА, ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН ХАМТЫН ГЭРЭЭ



Улаанбаатар 2025 он

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, байгууллагын дотоод дүрэм, журамд үндэслэн хөдөлмөрийн харилцааг зохицуулах багш, ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор ажил олгогчийг төлөөлж МУИС-ийн Захиргаа, хамт олныг төлөөлж Үйлдвэрчний Эвлэлийн Хороо (цаашид "ҮЭ-ийн хороо", хамтад нь "талууд" гэх) харилцан тохиролцож энэхүү хамтын гэрээг байгуулав.

1.2. Энэхүү гэрээнд заасан дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. "Ажил олгогч" гэж хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр хүнийг ажиллуулж байгаа тал;

1.2.2. "Ажилтан" гэж хөдөлмөрийн эрхлэлтийн харилцааны үндсэн дээр Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй удирдах, гүйцэтгэх, үйлчилгээний ажилтан;

1.2.3. "Багш" гэж Хөдөлмөрийн эрхлэлтийн харилцааны үндсэн дээр ажил олгогчтой Хөдөлмөрийн гэрээ байгуулан профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэглэлд ажиллаж буй багш;

1.2.4. "Үйлдвэрчний эвлэл" гэж МУИС-ийн нийт багш, ажилтныг төлөөлсөн МУИС-ийн ҮЭ-ийн Хороо.

1.3. Хамтын гэрээг харьяалах дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлж хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн хугацаанд үйлчилнэ.

1.4. Хамтын гэрээ нь МУИС-ийн багш, ажилтны эрх ашгийг хамгаалах, хөдөлмөрийн нөхцөл, нэмэгдүүлэх, олгох хугацаа, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэтгэмж, тусламж, олговрын хэмжээ, хөдөлмөрийн норм, норматив, шагнал урамшууллыг холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөлөөс дордуулахгүй байх, багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх, ажлын байрны баталгааг хангах зэрэг харилцааг зохицуулна.

Хоёр. Цалин хөлс, урамшуулал, тэтгэмж

2.1. Ажил олгогч нь багш, ажилтантай харилцан тохиролцож Хөдөлмөрийн гэрээ бичгээр байгуулж, гэрээний нэг хувийг багш, ажилтанд өгнө.

2.2. Талууд харилцан тохиролцож Хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулж болно.

2.3. Багш, ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд өөр ажилд шилжүүлэн ажиллуулах, шилжүүлэх боломжгүй бол үндсэн цалингийн 70 хувиар тооцож олговор олгоно.

2.4. Ажил олгогчийн санаачилгаар Хөдөлмөрийн гэрээг цуцалсан дараах тохиолдолд ажлаас халагдсаны тэтгэмжийг багш, ажилтанд олгоно:

2.4.1. Байгууллага, түүний нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, багш, ажилтны тоог цөөрүүлсэн бол 1-4 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгоно.

2.4.2. Мэргэжил, мэдлэг ур чадварын хувьд гүйцэтгэж байгаа ажилдаа тэнцэхгүй болох нь тогтоогдсон бол 1 сарын, эрүүл мэндийн хувьд ажилдаа тэнцэхгүй болох нь Хөдөлмөрийн хуулийн 80.1.3-т зааснаар тогтоогдсон бол 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно.

2.4.3. Багш, ажилтан өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан тохиолдолд МУИС-д ажилласан жилийг харгалзан дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно:

6 сараас-2 хүртэл жил ажилласан бол 1 сарын;
2-5 жил хүртэл ажилласан бол 2 сарын;
5-10 жил хүртэл ажилласан бол 3 сарын;

10-16 жил хүртэл ажилласан бол 6 сарын;
16-21 жил хүртэл ажилласан бол 9 сарын;
21-26 жил хүртэл ажилласан бол 12 сарын;
26-31 жил хүртэл ажилласан бол 15 сарын;
31-36 жил хүртэл ажилласан бол 18 сарын;
36 ба түүнээс дээш жил ажилласан бол 21 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгоно.

2.5. Өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 1 жилийн дунджаар тооцно.

2.6. МУИС-д тасралтгүй 25-аас дээш жил ажилласан МУИС-ийн багш, ажилтан өндөр насны тэтгэмжээ тогтоолгохын өмнө ажил үүргээ гүйцэтгэж байгаад наснаас нөхөцсөн бол Хамтын гэрээний 2.4.3-т заасан тэтгэмжийг олгоно. Тасралтгүй ажилласан хугацаанд чиг үүргийн хувьд өөр байгууллагад шилжин ажиллаж байгаад МУИС-д дахин ажилласан хугацаа хамаарахгүй.

2.7. Хамтын гэрээ байгуулахаас өмнө өндөр насны тэтгэврийн эрх үүссэн багш, ажилтнуудын хувьд нэг удаагийн тэтгэмжийг энэ хамтын гэрээний дагуу олгоно.

2.8. Ажил олгогч ажилтныг бөөнөөр халах тохиолдолд ажилтны төлөөлөгчид хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах үндэслэл, хамрагдах ажилтны нэр, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох өдрийн тухай мэдэгдэж, Хөдөлмөрийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3 дахь хэсэгт заасан асуудлаар хэлэлцээ хийнэ.

2.9. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс нь ажил олгогч, ҮЭ-ийн хороотой тэнцүү тооны төлөөллөөс бүрдэн ажиллана.

2.10. Хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй эсвэл нэг хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд хоёр цагийн, зургаан сараас нэг хүртэлх насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардах хүүхэдтэй эхэд нэг цагийн завсарлага нэмж олгоно. Хүүхэд хөхүүлэх ажилтны хүсэлтээр асрах завсарлагыг ажлын цагийг богиносгох хэлбэрээр олгоно.

2.11. Ажлын байрны онцлогийг харгалзан ажилтны хүсэлтээр нэгжийн удирдлагатай тохиролцон ажлын 8 цагийн эхлэх, дуусах цагийг харилцан тохиролцож дараах хуваариас сонгоно:
2.11.1. эхлэх цаг 07:30, дуусах цаг 16:30
2.11.2. эхлэх цаг 08:30, дуусах цаг 17:30
2.11.3. эхлэх цаг 09:30, дуусах цаг 18:30

2.12. Монгол Улсын их сургууль нь 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ажилтны цалинг 300,000 төгрөгөөр, 2026 оны 09 дүгээр сарын 01-ний багшийн цалинг “МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам”-ын 11.2 дах хэсгийг баримтлан нэмэгдүүлнэ. 2027 онд багш, ажилтны цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.

2.13. Хууль тогтоомжийн дагуу олговол зохих цалин хөлс, олговрыг хүндэтгэн үзэх шалтгаангүй тогтоосон хугацаанд олгоогүй нь нотлогдсон тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.7 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

2.14. Багшийг ээлжийн амралтаа авахад нь хичээлийн жилд хийсэн ажлын гүйцэтгэлд тохирох ажлын хөлсийг бүрэн олгоно.

2.15. Хөдөлмөрийн хуулийн 91 дүгээр зүйлд заасны дагуу илүү цагаар ажилласан тохиолдолд ажилтанд нэмэгдэл хөлс олгоно.

2.16. Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлуулан гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулсан тохиолдолд тохирох цалин хөлсийг нэмж олгоно.

2.17. Ажил олгогчийн шийдвэрээр шөнийн буюу шөнийн цагийн (22.00-06.00) нэмэгдэл хөлсийг тооцохдоо ажилласан цагаар нь бүртгэж, үндсэн цалингийн хэмжээтэй хувь тэнцүүлэн 1.2 дахин нэмэгдүүлж олгоно.

2.18. Багш, ажилтныг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулах, хуульд заасан хэмжээгээр шимтгэл төлөх, тайлагнах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлснийг баталгаажуулна.

2.19. Багш кредит цагаа бүрэн биелүүлээгүй нь багшийн буруугаас шалтгаалаагүй нь тогтоогдсон бол гүйцэтгэсэн ажилд нь ногдох цалин хөлс болон үндсэн цалингийн зөрүүг нөхөн олгоно.
2.20. МУИС-тай хамтран ажиллаж буй банктай байгуулсан гэрээний заалтуудыг мөрдөж ажиллахаас гадна ҮЭ-ийн хороо нь МУИС-ийн Захиргаанаас шаардлагатай мэдээллийг авах эрхтэй.

Гурав. Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл

3.1. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөр хамгааллын журамд ҮЭ-ийн хороо, МУИС-ийн Захиргаа хамтран хяналт тавина.
3.2. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн, хэрэглэх хугацааг тогтоож, зохих хугацаанд нь олгоно. Хамгаалах хувцас, хэрэгсэл, бусад зүйлээр хангаагүй тохиолдолд үйлчилгээ эрхлэхгүй байх.
3.3. Багш, ажилтан Хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа зөрчигдөн амь нас, эрүүл мэндэд нь хортой, сөрөг нөлөө үзүүлэх бодит нөхцөл байдал бий болсон тохиолдолд нэн даруй ажлыг зогсоож, ажил олгогчид мэдээлэх, нөхцөл байдал хэвийн болтол хүлээх.
3.4. Ажил олгогч анги, танхим, тэнхимүүдийн өрөө тасалгаанд тодорхой хуваарийн дагуу урсгал засвар хийх, ширээ сандлын стандартыг баримтлан шинэчлэх, багш, ажилтны ажиллах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг шат дараалан авна.
3.5. Хортой нөхцөлд ажилладаг багш, ажилтнуудад ажлын нэг хоногт нэг багш, ажилтанд 0,5 литр сүү олгоно.
3.6. Зарим шаардлагатай ажлын байр болох номын сан, үйлчилгээний ажилтан, лабораторийн ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тогтоолгоно.
3.7. Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн үзлэгийг жилд 1 удаа хийнэ.
3.8. Ажил олгогч бүх насны багш, ажилтныг нарийн мэргэжлийн эмч нарын насны ялгаатай, багцын үзлэгт оруулах ажлыг зохион байгуулж, зардлыг хариуцна.
3.9. Өвлийн улиралд хичээлийн байруудын дулаан хангамжийг ажил олгогч хэвийн түвшинд байлгана.
3.10. ҮЭ-ийн хороо нь ажил олгогчтой хамтарч хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар холбогдох хууль тогтоомж, зааварчилгааг багш, ажилтнуудад танилцуулах, сурталчлах, сургалт явуулна.
3.11. МУИС-ийн талбайг түрээслэн үйл ажиллагаа явуулж буй хоол, цайны газар гэх мэт үйлчилгээний газруудын үйлчилгээний чанар, ариун цэвэрт ҮЭ хороо, МУИС-ийн Захиргаатай хамтран хяналт тавьж ажиллана.

Дөрөв. Багш, ажилтны мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх

4.1. Ажил олгогчийн зөвшөөрлөөр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан ажилтны суралцсан цагийг ажилласан цагт нь оруулж, цалинг бүрэн олгоно.
4.2. Багш, ажилтныг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журмын хэрэгжилтэд хяналт тавих, ил тод, мэдээллээр хангах тал дээр хамтран ажиллах.

Тав. Нийгэм, ахуйн хангамж, хөнгөлөлт

5.1. Орон сууц, амины орон сууц захиалах хүсэлтэй багш, ажилтанд зээл авахад нь дэмжлэг үзүүлнэ.
5.2. Тус сургуульд ажиллаж байсан багш, ажилтан болон тус сургуулиас өндөр насны тэтгэвэрт гарсан багш, ажилтан нас барвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгоно.

5.3. Багш, ажилтны төрүүлсэн болон үрчлэн авсан эцэг, эх, хүүхэд, гэрлэгчид, түүний эцэг, эх нас барахад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлнэ.

5.4. Хичээлийн байруудад багш нарын амралтын өрөөг үе шаттай нээн, завсарлагаагаар тав тухтай байх орчныг хангаж өгнө.

5.5. ҮЭ хороо, МУИС-ийн Захиргаа нь багш, ажилтны хүүхдийг цэцэрлэгт хамруулах зорилгоор Сургуулийн өмнөх боловсролын байгууллагатай хамтран ажиллах боломжийг судлан, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.6. ҮЭ-ийн хороо гишүүдээ шагнал урамшуулалд тодорхойлсон саналыг МУИС-ийн захиргаанд тавина.

Зургаа. Захиргаа ба Үйлдвэрчний эвлэлийн хамтын ажиллагаа

6.1. ҮЭ-ийн хороог үйл ажлаа явуулахад шаардлагатай өрөө, ажиллах нөхцөлөөр хангана.

6.2. МУИС-ийн ҮЭ-ийн хорооны дарга Ректорын зөвлөлийн хуралд, ҮЭ-ийн хорооны бүлгийн дарга нар нь бүрэлдэхүүний сургуулийн захирлын зөвлөлийн хуралд багш, ажилтны нийтлэг хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудлыг хэлэлцэхэд оролцож болно.

6.3. Ажил олгогч МУИС-ийн дараах асуудлаар бичиг баримт батлах, тушаал шийдвэр гаргахдаа ҮЭ-ийн хорооны саналыг авна:

6.3.1. Цалингийн сүлжээ, түүнийг шинэчлэх;

6.3.2. Багш, ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай холбоотой дүрэм, журам боловсруулж батлах;

6.3.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, тэдгээртэй холбоотой төлөвлөгөөг боловсруулахад санал авах.

6.4. ҮЭ-ийн хорооны төлөөлөгчид дараах үйл ажиллагаанд оролцоно:

6.4.1. Хамтын гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх комисс;

6.4.2. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс;

6.4.3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хэлэлцэх комисс.

6.5. Захиргаа, захиргааны нэгж нь ажил олгогч ба ҮЭ-ийн хорооны хооронд хамтын гэрээний төсөл боловсруулах, хэлэлцээр хийхэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

6.6. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй ҮЭ-ийн идэвхтэн сонгуультан ҮЭ-ийн сургалтад хамрагдах, хурал зөвлөгөөн, семинар, ярилцлагад оролцох үед албан ёсны баримтыг үндэслэн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал чөлөө олгоно.

6.7. ҮЭ-ийн гишүүн профессор, багш, ажилтны зөвшөөрлийг үндэслэн үндсэн цалингаас нь 1%-ийн татварыг суутгаж, МУИС-ийн ҮЭХ-ны дансанд МУИС-ийн Захиргаа шилжүүлнэ.

6.8. МУИС-ийн ҮЭ-ийн хорооны даргын ажлын үнэлгээний В цаг дээр 3 кредит, ҮЭ-ийн хорооны бүлгийн даргын ажлын үнэлгээний В цаг дээр 2 кредит нэмнэ. Ажилтны бүлгийн даргын хувьд цалингийн 15 хувиар жилийн эцэст тооцож, гишүүдийн хураамжаас урамшуулал тооцож олгоно.

6.9. МУИС-ийн Хөдөлмөрийн маргаан таслах комиссын гишүүдэд нэг удаагийн хуралд оролцсон тохиолдолд ажлын хөлсийг журмын дагуу тооцно.

6.10. Багш, ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулахад чиглэсэн, хамт олны олонхын санал авсан ажлуудыг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал нь ҮЭ-ийн Хорооны бүлгийн даргатай зөвшилцөн хичээлийн жилд хэрэгжүүлнэ.

6.11. ҮЭХ-ны үйлдвэрчний эвлэлийн ажилтан, сонгуультанд тухайн сонгуульт ажилтай нь холбогдуулан сахилгын шийтгэл ногдуулах, хэлэлцээрт оролцсоных нь төлөө өөр ажилд шилжүүлэх, ажил олгогчийн санаачилгаар хэлэлцээрийн туршид болон хэлэлцээр дууссанаас хойш гурав жилийн дотор ажлаас халахыг хориглоно.

Долоо. Бусад

7.1. Энэхүү гэрээ нь талуудын бүх төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулж, холбогдох дүүргийн Засаг даргын тамгын газрын Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

7.2. Ажил олгогч, ҮЭ-ийн хорооноос баталсан албан тушаалтнууд Хамтын гэрээнд заасан ажлын биелэлтэд байнга хяналт тавьж, жилд 1 удаа хамт олонд биелэлтийн талаар мэдээлж байна.

7.3. Хамтын гэрээ батлах, биелүүлэх явцад үүссэн санал зөрүүтэй асуудлыг "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 40 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

7.4. ҮЭ-ийн хороо ажил олгогчид дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

7.5. Гэрээний биелэлттэй холбоотой асуудлыг талууд зөвшилцөж шийдвэрлэнэ.

МУИС-ИЙН ЗАХИРГААГ ТӨЛӨӨЛЖ

Төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор
..... (Б.Даваасүрэн)

Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор
..... (С.Гомбобаатар)

Инженер, технологийн сургуулийн захирал
..... (Ч.Сономдагва)

Хөрөнгө оруулалтын газрын дарга
..... (Д.Бадмаанямбуу)

Сургалт, хөтөлбөр, чанар баталгаажуулалтын газрын дарга
..... (С.Булгантамир)

Хуулийн зөвлөх
..... (Б.Болормаа)

ҮЭ-ИЙН ХОРООГ ТӨЛӨӨЛЖ

ҮЭ-ийн хорооны дарга
..... (Т.Төртогтох)

ҮЭ-ийн хорооны гишүүн
..... (А.Пагамсүрэн)

ҮЭ-ийн хорооны гишүүн
..... (С.Батбилэг)

ҮЭ-ийн хорооны гишүүн
..... (Б.Дэлгэрмаа)

ҮЭ-ийн хорооны гишүүн
..... (Д.Эрдэнэбаатар)

ҮЭ-ийн хорооны гишүүн
..... (С.Ариунбилэг)

БҮРТГЭВ № 26
НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
2025 оны 12-р сарын 30-ны өдөр